# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024.12.13 Алтай хот

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ | | | | | | | |
| Зорилт 1.1. Монгол Улсын сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангана. | | | | | | | |
| 1 | Монгол Улсын Ерөнхий сайдын батламжийн биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн тайлагнах | Тайлагналтын тоо | 1 | 1 | I улиралд | Ерөнхий сайдын батламжийн 7 заалтыг карталж хэлтсүүдэд хүргүүлсэн бөгөөд 12.10-ны дотор нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн, Ерөнхий сайдын ажлын албанд 12.13-ны өдрийн албан бичгээр хүргүүллээ. | 100 |
| 2 | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн ЗГХЭГ-т тайлагнах | Тайлагналтын тоо | 2 | 2 | I,III улирал | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний заалтуудыг холбогдох хэлтсүүдэд картлан хэрэгжилтийг хангаан ажиллалаа.<br>Жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг даргын хүлээх 32 заалтын хэрэгжилт 91,87 хувьтай дүгнэгдэж 12 дугаар сарын 13-ны өдөр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүллээ. | 100 |
| 3 | Монгол Улсын Шадар сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн тайлагнах | Тайлагналтын тоо | 1 | 1 | I улирал | Монгол Улсын Шадар сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний 16 заалтыг холбогдох хэлтсүүдэд картлан хүргүүлж хэрэгжилтийг хангаан ажиллалаа.<br>Гэрээний биелэлтийг 96,8 хувьтай хэрэгжүүлэн ажиллаж 12 дугаар сарын 13-ны өдөр хүргүүллээ. | 100 |
| 4 | Гадаад харилцааны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах | Тайлагналтын тоо | 1 | 1 | II, IV улирал | Гадаад харилцааны сайдын гэрээнд тусгагдсан 11 ажил, арга хэмжээг холбогдох агентлагуудад картлан хүргүүлж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилтийг хангаж ажиллаа. Гэрээний хэрэгжилтийг 98,2 хувьтай хэрэгжүүлэн ажиллаж Гадаад харилцааны яаманд хүргүүллээ. | |
| 5 | Цахим хөгжил харилцаа, холбооны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн тайлагнах | Тайлагналтын тоо | 1 | 1 | IV улирал | Цахим хөгжил харилцаа, холбооны сайд гэрээнд тусгагдсан ажил, арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан Цахим хөгжил харилцаа холбооны төрийн захиргааны удирдлагын хэлтэс хүргүүлж, холбогдох хэлтэс, агентлагуудад картлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Жилийн эцсийн байдлаар биелэлтийг 2024 оны 12 сарын 25-ны өдрийн дотор нэгтгэн тайлагнана. | 100 |
| **Зорилт 1.2. Аймгийн бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 6 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтийг тайлагнах | Тайлагналтын тоо | 4 | 4 | I-IV улиралд | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2023 оны 4-р улирал, 2024 оны 1, 2, 3 дугаар улирлын тогтоолын биелэлтийг 88,2 хувьтай биелүүлж, тайланг хугацаанд нь хүргүүллээ. 2024 оны 4-р улирлын тогтоолын хэрэгжилтийг 2025 оны 1 сарын 15-ны дотор нэгтгэж хүргүүлнэ. | 100 |
| 7 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн АИТХ-д тайлагнах. | Тайлагналтын тоо | 1 | 1 | IV улиралд | ЗДҮАХ-ийн арга хэмжээний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр нэгтгэж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэлээ.<br>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит хуралдаанаар 87,5 хувьтай дүгнэгдлээ. | 100 |
| **Зорилт 1.3. Цахим хөгжил, мэдээлэл технологийн чиглэлээр** | | | | | | | |
| 8 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, нээлттэй мэдээллийг www.shilen.gov.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэх | Хэрэгжилтийн хувь | 86% | 90%-иас доошгүй | I-IV улиралд | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод байлгахаар заасан мэдээллийг нээлттэй мэдээллийн shilen.gov.mn системд байршуулах ажлыг зохион байгуулан төрийн байгууллагуудад сургалт хийж, байгууллагуудыг бүртгүүлэн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | админ эрх олгож, аймгийн Засаг даргын тамгын газрын мэдээллийг 12 дугаар сарын 01-ний дотор байршуулан ажиллаж байна. Хэрэгжилт хангалтгүй байгаа байгууллага, сумдад эрчимжүүлэн ажиллах чиглэл хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь 1-р улирал 74,6%, 4-р улирал 66,9% | |
| 9 | “Цахим аймаг” бодлогын зөвлөмж, “Аймгуудын цахим шилжилтийн тайлан-2023”-т туссан аймгийн цахим шилжилтийн үнэлгээний үзүүлэлтийг үе шаттайгаар сайжруулах арга хэмжээ авах | Арга хэмжээний тоо | 1 | 1 | I-IV улиралд | “Цахимд хэвшье” арга хэмжээг 2024 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Говь-Алтай аймагт зохион байгууллаа. Цахим хөгжил, харилцаа холбооны яам "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн хүрээнд цахим шилжилтийг үндэсний хэмжээнд эрчимжүүлэх зорилгоор “Цахимд хэвшье” уриатай “Цахим хөгжлийн өдөрлөг” арга хэмжээг харьяа, салбар байгууллагуудын дэмжлэгтэйгээр харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын 30 гаруй төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоотой хамтран зохион байгуулав. | 100 |
| 10 | 24/7 цагаар ажиллах ухаалаг цэгийг шинээр байгуулах, киоск, хөдөлгөөнт цэг, төхөөрөмжийг нэвтрүүлэх, тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх | Шинээр нэвтрүүлсэн төхөөрөмжийн тоо | 0 | 1 | I-IV улиралд | Энэ онд Төрийн архивын газрын байр, Шүүхийн тамгын газарт шинээр төрийн үйлчилгээний киоск машин байрлуулсан. Есөнбулаг, Дэлгэр, Цогт сумдад 6 байршилд төрийн цахим үйлчилгээний ХУРДАН киоск машиныг нэмж байршуулах саналыг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.<br>Тус яамнаас 3 киоск машин Төрийн цахим үйлчилгээний хэлтэс ирсэн ба суурьлуулалт хийхээр хүлээгдэж байна. | 100 |
| 11 | Төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг дахин загварчлах, холбогдох судалгаа хийх | Арга хэмжээний тоо | 1 | 1 | I-II улиралд | Монгол улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.1 дэх хэсэгт “Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулах” гэж заасныг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлэх хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайдын 2023 оны А/53 дугаар тушаалаар "Цахим аймаг" бодлогын зөвлөмж батлагдсан.<br>Дээрх бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хэсэг тус аймагт 2024 оны 02 дугаар сарын 29, 03 дугаар сарын 01-ний өдрүүдэд ажилласан.<br>Ажлын хэсэг төрийн байгууллагаас хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг дахин загварчилах, холбогдох судалгааг хийж нэгдсэн эмнэлэгийн цаг авах, цуцлах, согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрал олгоход шаардлагтай бүрдүүлэх материалын цахимаар хүлээн авах боломжийг бүрдүүлэн дахин загварчилсан.<br>Мөн төрийн байгууллагуудын бичиг хэрэг, мэдээлэл технологи хариуцсан 80 гаруй ажилтнуудад "Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем"-ийн талаар сургалт зохион байгуулсан. | |
| **Зорилт 1.4. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хуулийн дагуу барагдуулж шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулна.** | | | | | | | |
| 12 | Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт бичгээр, 7048-1111 тусгай дугаараар, хайрцгаар, цахим хаягаар, биечлэн ирүүлсэн өргөдөл, гомдлыг цаг тухай бүрт хүлээн авч, ERP системд бүртгэн, шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавих, хугацаа хэтэрсэн өргөдөл гомдолгүй байх | Шийдвэрлэлтийн хувь/ Хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн өргөдөл, гомдлын тоо | 95,6 хувь/ 51 | 96 хувь/0 | I-IV улиралд | Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлагууд болон сумдаас нийт 845 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 727 буюу 86%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба 118 өргөдөл, гомдол шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна. Хандив тусламж дэмжлэг хүссэн 160 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авч, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, сургалтын төлбөр, эмчилгээний төлбөрт нийт 111,070 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. /2024 оны 11 сарын 29-ний байдлаар/ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах-1111 төвөөс шилжин ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг эрс сайжруулж, хугацааг 2 дахин бууруулах | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа | 30 хоног | 15 хоног | I-IV улиралд | Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах-1111 төвөөс шилжин ирсэн 47 өргөдлийг хүлээн авч удирдлагад танилцуулан холбогдох албан байгууллагад шилжүүлэн, шийдвэрлэлтийн байдлыг иргэнд 7048-1111 утсаар болон , албан бичгээр хүргүүлэн ажилласан. Шийдвэрлэлтийн дундаж хоног 14,8 байна. | 100 |
| 14 | Аймгийн Засаг даргын Тамгын газар, 18 сум, 24 агентлагийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг улирал бүр хүлээн авч, нэгтгэн Засаг даргын Удирдлагын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт заасан хугацаанд хүргүүлэх | Хугацаанд нь хүргүүлсэн тайлангийн тоо | 4 | 4 | I-IV улиралд | Төрийн байгууллага албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын I, II, III улирлын мэдээг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.2024 оны жилийн эцсийн тайланг нэгтгэж хугацаанд нь хүргүүлэхээр бэлтгэж байна. | 100 |
| 15 | Ижил агуулгын хүрээнд ихээр өргөдөл, гомдол ирж буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, холбогдох хэлтэс агентлагуудад хүргүүлэн шуурхай арга хэмжээ авах | Дүн шинжилгээ хийсэн тайлан | - | 1 | I-IV улиралд | Агуулгыг хэт задгай буюу агуулгаа багцлаагүй жагсаалт болгон, агуулга дотор байгууллагын хөдөлмөрийн харилцаатай холбоотой хүсэлт, иргэдийн дуудлага зэргийг оруулахгүйгээр гомдолд буюу хамгийн их давтамжтай гомдлын агуулгыг тодорхойлох байдлаар багцлан ирүүлэх, тайланд анхаарах асуудлын тухай сум, агентлагийн бичиг хэргийн ажилтанд зөвлөгөө мэдээлэл хүргэж ажиллаж байна. Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст дүн шинжилгээ хийлгэхээр бэлтгэж байна. | 90 |
| Зорилт 1.5. Чадахуйн зарчимд нийцсэн мэргэшсэн албан хаагчдаар төрийн албыг бэхжүүлж, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж, хөгжүүлнэ. | | | | | | | |
| 16 | Төрийн байгууллагуудаас ирүүлсэн сул орон тооны захиалгыг нэгтгэн, шилжих сэлгэх ажлын байрны жагсаалтыг хуулийн хугацаанд олон нийтэд нээлттэй мэдээлж сул орон тоог чадахуйн зарчим болон шатлан дэвшүүлэх тогтолцоог мөрдүүлэн нөхөх арга хэмжээ авах | Нээлттэй мэдээлсэн тоо | 4 | 4 | I-IV улиралд | Төрийн байгууллагуудаас ирсэн сул орон тооны захиалгыг нэгтгэн жагсаалтыг гаргаж, 4 удаа нийт 257 сул ажлын байрны шилжих сэлгүүлэх зарыг аймгийн цахим хуудас, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудаст журамд заасан хугацааны дагуу нийтлэлээ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Төрийн жинхэнэ албаны ерөнхий, тусгай шалгалт болон төсвийн ерөнхийлөн захирагчийн сонгон шалгаруултыг тогтоосон хугацаанд болон онцгой нөхцөлд захиалга өгч зохион байгуулан, нэр дэвшүүлэх, томилох үйл ажиллагаанд хяналт тавин, зөвлөмж өгч ажиллах | Сонгон шалгаруулалт зарласан ажлын байрны тоо | 233 | 100-аас доошгүй | I-IV улиралд | 2024 оны жилийн эцсийн байдлаар төрийн албаны ерөнхий шалгалтыг Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоол, 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 4 удаа зохион байгууллаа.<br>"Төрийн албаны ерөнхий шалгалт"-ын бүртгэлийг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар бүртгэж, нийт 4 улирлын шалгалтын бүртгэлд 493 иргэн хамрагдлаа.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар ерөнхий шалгалтуудаар нийт 134 иргэн нөөцөд бүртгэгдлээ.<br>Мөн 2024 онд сул орон тооны нийт 168 ажлын байрны захиалгыг программд оруулж, төрийн албаны зөвлөлөөр хянуулж, тусгай шалгалтад тэнцсэн 51 иргэдийг томилуулахаар нэр дэвшүүлж нөхлөө. | 100 |
| 18 | Төрийн жинхэнэ албан хаагчийг тангараг өргүүлэх ёслолыг зохион байгуулах | Тангараг өргүүлэх ёслолын тоо | 1 | 1-ээс доошгүй | I-IV улиралд | Төрийн албан хаагчийн тангараг өргөх ёслолыг 2024 онд 3 удаа зохион байгуулж, нийт 114 төрийн жинхэнэ албан хаагчийг тангараг өргүүллээ.<br>2024 оны 03 дугаар сарын 28-нд 76 төрийн албан хаагч, 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр буюу Төрийн албаны өдрөөр 6 төрийн албан хаагч, 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр 32 төрийн албан хаагчдын тангаргийг Төрийн албан хаагчийн тангараг өргөх ерөнхийлөгчийн зарлиг, шинэчлэгдсэн журмын дагуу өргүүллээ. | 100 |
| 19 | Төрийн албан хаагчдад зэрэг дэв олгуулах ажлыг зохих хууль журмын дагуу зохион байгуулах | Захирамжийн тоо | 2 | 1 | I улиралд | Төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв олгох танилцуулга, судалгааг төрийн байгууллагуудаас хугацаатай бичгээр авч, нэгтгэлийг хийж, 187 төрийн албан хаагчийн зэрэг дэвийг Төрийн албаны тухай хууль, Улсын Их Хурлын 2019 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 21 дүгээр тогтоолын дагуу шинээр олгох, ахиулах шийдвэрийг аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Б/22 дугаар захирамжаар гаргалаа. | |
| 20 | Төрийн албаны тухай хууль болон төрийн албаны стандарт, Төрийн албан хаагчдын ёс зүйн хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр сумдын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах | Ажиллах сум, байгууллагын тоо | - | 10-аас доошгүй | I-IV улиралд | Төрийн албаны шинэтгэл, Ёс зүйн тухай хуулийн талаар Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуунаар ахлуулсан ажлын хэсгийн сургалтад төрийн байгууллагуудын 480 гаруй албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Төрийн албаны албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор Төрийн албаны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиудаар Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран 12 байгууллага, 6 сумын 636 төрийн албан хаагчдад сургалтыг хийж, мэдээллээр ханган ажиллалаа. Мөн аймгийн прокурорын байгууллагаас зохион байгуулсан "Эрүүдэн шүүхээс ангид байх" зөвлгөөнд салбар зөвлөлийн дарга 230 төрийн тусгай албан хаагчдад төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээний талаар мэдээлэл хийсэн. Мөн Төрийн байгууллага бүр дээр ёс зүйн дэд хороог байгуулсан шийдвэрийг гаргуулж, 38 байгууллагын мэдээллийг цахимд оруулсан. Ёс зүйн зөрчлийн тайлан мэдээг хугацаанд нь Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. | 90 |
| 21 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах | Хэрэгжилтийн хувь | 80 хувь | 90%-иас доошгүй | I-IV улиралд | Аймгийн Засаг даргын Тамгын газрын сургалтын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд 52 удаагийн сургалтад 50 албан хаагч хамрагдсан. Хэрэгжилт 95 хувьтай. | 100 |
| 22 | Аймгийн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг | Хэргжилтийн хувь, тайлангийн | 85 хувь | 90%-иас доошгүй | I-IV улиралд | Аймгийн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн батлуулсан бөгөөд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж, биелэлтийг нэгтгэн дүгнэх. | тоо | | | | хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт 91 хувьтай. | |
| 23 | Төрийн албан хаагчдыг сургалтад хамруулах чадавхжуулах ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэрэгжүүлнэ. | Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын тоо | 3479 | 3700-аас доошгүй | I-IV улиралд | 2024 оны 3 дугаар сарын 28-нд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтад байгууллагын нийт албан хаагчид бүрэн хамрагдсан. Албан хаагчид хууль эрх зүй болон чиг үүргийн дагуу нийт 38 нэр төрлийн гадаад, дотоодын сургалтад хамрагдсан байна. Төрийн Архивын тасгаас сум, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудад "Архивчдын хөгжил, сургалт арга зүйн төв"-тэй хамтран 2024 оны 04 дүгээр сарын 29,30-ны өдрүүдэд чадавхижуулах сургалтыг зохион сумдын болон агентлаг, албад байгууллагуудын 145 албан хаагчдыг чадавхижуулан сертификат олгосон.<br>Нийт давхардсан тоогоор 3708 албан хаагч сургалтад хамрагдсан байна. | 90 |
| 24 | Аймгийн Засаг даргын Тамгын газарт чанарын менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах | Стандарт нэвтрүүлсэн эсэх | - | 1 | I-IV улиралд | Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх ажлыг амжилттай зохион байгууллаа. Уг ажлын хүрээнд 2024 оны 2 дугаар сарын 19-нд "Тэнүүн сэтгэмж" ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажилласан.<br>"Чанарын гарын авлага", байгууллагад хэрэгжүүлэх 9 журмыг боловсруулсан. 2024 оны 6 дугаар сарын 5-нд "Кю сертф" ХХК-аар баталгаажуулалтын 1 дүгээр шатны аудитыг, 6 дугаар сарын 17-18-нд 2 дугаар шатны баталгаажуулалтын аудитыг хийлгэж, 90.7 оноогоор үнэлүүлсэн. | 100 |
| 25 | Удирдлагын академитэй хамтран багийн Засаг дарга нарыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах | Зохион байгуулсан сургалтын | - | 1 | I-IV улиралд | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 303 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн нийт багийн Засаг дарга нарыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тоо | | | | чадавхжуулах богино хугацааны зорилтот сургалтыг 2024 оны 3 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд Алтай хотод зохион байгууллаа.<br>"Иргэн төвтэй хөгжлийн төлөө" сэдэвт сургалтад 65 багийн Засаг дарга оролцсон. Улсын хэмжээний нийт оролцогчдоос Дэлгэр сумын Баян-Өндөр багийн Засаг дарга шилдэг оролцогчоор шалгарч БНСУ-д сургалтад хамрагдсан. | |
| 26 | Байгууллагын албан хаагчдад гадаад хэл, хууль, компьютер тоног төхөөрөмж, хэрэглээний программууд дээр ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо | - | 4 | I-IV улиралд | Аймгийн Засаг даргын Тамгын газрын сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант онд "Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем", "5S-ийн зарчим", "Зөөлөн ур чадвар", "Харилцааны ур чадвар", "Харилцаа ба хандлага", "Стрессээс хэрхэн ангижрах вэ?", "Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" зэрэг нийт 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор 214 албан хаагч хамрагдсан. "Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс сэргийлэх нь" сургалт, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр хэрэгжих болон шинэчлэгдэн батлагдсан 9 хууль, өдөр тутам хэрэглэгддэг 2 хууль, "Үр дүнд суурилсан хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй" зэрэг сургалтыг нийт албан хаагчдад зохион байгууллаа. Мөн төрийн албан хаагчдад зориулсан англи хэлний дунд шатны эрчимжүүлсэн сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| 27 | Төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлуулах | Батлагдсан албан тушаалын тодорхойлолт | - | 10-аас доошгүй | I-IV улиралд | Төрийн албаны зөвлөлийн хурлаар зөвшөөрөл олгогдсон 5 албан тушаалын тодорхойлолтыг тамгын газрын даргын тушаалаар батлуулсан.<br>Төрийн үйлчилгээний албан тушаалын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тодорхойлолтыг төсөл байдлаар боловсруулан бэлтгэж байна. | |
| 28 | Монгол Улсын цол, төрийн дээд одон, медаль, Алдарт эхийн одонгоор шагнуулахаар ирүүлсэн материалыг Ерөнхийлөгчийн Тамгын газарт тухай бүр өргөн мэдүүлж байх | Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан тоо<br>Able программд оруулсан хувь | 6<br><br>100% | 10-аас доошгүй<br><br>100% | I-IV улиралд | Сумдын түүхт 100 жилийн ойг тэмдэглэхтэй холбоотой сум орон нутагтаа олон жил үр бүтээлтэй ажилласан иргэдийг Монгол Улсын цол, төрийн дээд одон, медалиар шагнуулахаар ирүүлсэн нийт 517 хүний материалыг 28 удаагийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан.<br>Аймгийн хэмжээнд "Алдарт эх"- ийн нийт 194 материал хүлээн авч нягтлан үзэж хууль, журмын шаардлага хангаагүй 15 материал хасагдаж, бүрдэл дутуу 18 материалын бүрдлийг хангуулан I зэргийн одонд 16, II зэргийн одонд 163 нийт 179 эхийн материалын бүрдлийг хангуулан Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилж, шагнуулсан. | 100 |
| 29 | Аймгийн шагналаар шагнуулахаар ирүүлсэн материалын бүрдлийг хангаж, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэх | Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан тоо | 25 | 10-аас доошгүй | I-IV улиралд | Аймаг орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан нийт 236 иргэний материалыг Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Үүнээс аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр 12 , аймгийн Засаг даргын "Жуух бичиг" -ээр 224 иргэнийг шагнасан. | 100 |
| 30 | Монгол Улсын цол, төрийн дээд одон, медаль, Алдарт эхийн одонгоор шагнагдсан иргэдэд шагнал гардуулах арга хэмжээг цаг тухайд нь зохион байгуулах | Арга хэмжээний тоо | 2 | 2-оос доошгүй | I-IV улиралд | Монгол Улсын цол, төрийн дээд одон, медалиар шагнагдсан иргэдэд шагнал гардуулах 2 удаагийн ёслолын арга хэмжээг зохион байгуулсан.<br>Мөн "Алдарт эх" -ийн I зэргийн одонгоор 16, II зэргийн одонгоор 163 эх шагнагдсан бөгөөд шагнал гардуулах арга хэмжээг 2024 оны 05 сарын 31-ний өдөр амжилттай зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | Аймгийн аваргуудад шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулна. | Арга хэмжээний тоо | 2 | 2 | I-IV улиралд | 2024 оны 02 сарын 28-ны өдөр аймгийн аварга малчин, саальчин, тэмээчин, тариаланч, алдарт уяач, уяач тэмээчин нийт 344 иргэнд хүндэтгэл үзүүлж, шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг ХХААГ, Ардын дуу бүжгийн Алтай чуулгатай хамтран зохион байгуулсан. | 100 |
| 32 | Гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгалж, харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар ахиц гарган ажиллах | Арга хэмжээний тоо | 4 | 4 | I-IV улиралд | Аймгийн Засаг даргын гадаад айлчлал, гадаад хамтын ажиллагаа, гадаад арга хэмжээний төлөвлөгөө,тайлан, илтгэх хуудсыг ГХЯ-д хүргүүлэх, чиглэл авч ажиллаж байна.<br>2024 оны байдлаар БНХАУ-ын ШУӨЗО-ны Цонж аймагтай мод суулгацыг нийлүүлэх чиглэлээр, мөн орон нутгийн онцлог, давуу талд түшиглэн хил дагуух бүс нутгийн гадаад хамтын ажиллагааг идэвхижүүлэн, уламжлалт харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хандив, зээл, тусламжийг оновчтой байршуулан эх үүсвэрийг нэмэгдүүлж үр өгөөжийг нь дээшлүүлэн ажиллаж байна. БНХАУ-ын Ганьсу муж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шинжаан Уйгарын Өөртөө Засах Орны Цонж аймагтай хамтын ажиллагааны хүрээнд боомтын бүтээн байгуулалт, боловсрол, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллаж байна. Мөн БНСУ-ын Вандо, Чонбуг мужуудтай ажиллах хүч гаргах чиглэлээр гэрээ, хэлэлцээр хийхээр бэлтгэн ажиллаж байна. | 100 |
| 33 | NEAR олон улсын байгууллагын төсөл, арга хэмжээнүүдтэй хамтран ажиллах, оролцох | Арга хэмжээний тоо | 1 | 2-оос доошгүй | I-IV улиралд | 2024 оны 10 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд БНХАУ-ын Хунань мужийн Жанжяже хотноо "Шинэчлэлийн хороог үүсгэн байгуулах хурал" болон "Ногоон хөгжлийн чуулга уулзалт"-д холбогдох 2 албан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалтныг оролцуулахаар холбогдох материалыг бүрдүүлж оролцуулсан.<br>NEAR хүүхдийн гар зургийн уралдааны удирдамжийг ЕБС-иудад хүргүүлж ажилласан. | |
| 34 | “Шинэ сэргэлтийн бодлого”, Боомтын сэргэлтийн хүрээнд Нарансэвстэй-Мазушань хилийн боомтыг нээн ажиллуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж хамтран ажиллах | Арга хэмжээний тоо | 1 | 2-оос доошгүй | I-IV улиралд | Нарансэвстэй-Мазушань боомтыг нээн ажиллуулах чиглэлээр судалгаа хийж, дүгнэлт, зөвлөмж гаргаж танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүний нийт 3 хуралдаанд оролцсон.<br>Аймгийн удирдлагуудаас тавьсан хүсэлтийн дагуу 2024 оны 05 дугаар сард Нарансэвстэй-Мазушань боомтын нөхцөл байдалтай танилцах дэд ажлын хэсэг нөхцөл байдалтай газар дээр нь танилцсан.<br>Өргөстэйн заставаас Нарансэвстэй боомт хүртэлх 250 км авто замын техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг боловсруулах, хууль эрх зүйн зохицуулалтыг шийдвэрлэх, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр болсон. 2024 оны 05 дугаар сарын 09-12-ний өдрүүдэд “Нарансэвстэй-Мазушань” боомтыг нээх ажиллуулах чиглэлээр судалгаа хийж, дүгнэлт , зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэг Говийн их дархан цаазат газрын А,Б хэсэгт ажилласан.<br>-2024 оны 11 дүгээр сарын 17-21-ний өдрүүдэд Нарансэвстэй боомт орчимд орон нутгийн болон нийслэлийн сэтгүүлчдийн баг ажилласан.<br>- Нарансэвстэй боомтыг сэргээж нээхтэй холбоотой шаардлагатай мэдээлэл цуглуулах, боловсруулах, нэгтгэх ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн 2023 оны тайланг нэгтгэн, 2024 онд хэрэгжүүлэх ажлуудыг нэгтгэн төлөвлөгөө гаргаж тайланг холбогдох газруудад заасан хугацаанд хүргүүлэх | Төлөвлөгөө, тайлангийн тоо | - | 2 | I,IV улирал | Аймагт Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн 2023 оны тайланг нэгтгэж, 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг сум, агентлагуудаас авч нэгтгэсэн.<br>Аймгийн хэмжээнд 12 олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран ажиллаж байна.<br>Дэлхийн 90 гаруй оронд үйл ажиллагаагаа явуулдаг хүмүүнлэгийн, хөгжлийн, олон улсын байгууллага болох Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагынГовь Алтай Орон Нутгийн Хөтөлбөр нь 2027 оны 9 сарын 30-ны өдрийг хүртэл сунгагдсан бөгөөд 2024–2027 оны "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг үзэглэх үйл ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан. | 90 |
| 36 | Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж, тэмдэглэл үйлдэн, шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд хэлтсүүдийн оролцоог хангуулна | Зохион байгуулагдсан хурлын тоо | 45 | 45 | I-IV улирал | Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 29 удаагийн хурлыг зохион байгуулж, хурлын тэмдэглэлээс 167 баримт гаргаж холбогдох хэлтэс, албан хаагчдад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | 100 |
| 37 | Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нарын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, хянаж, баталгаажуулж хэргэжилтийг хангуулахад хяналт хийж зөвлөмж өгажиллах | Агентлагийн тоо | 24 | 24 | I улирал | Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 25 агентлагийн дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулж хэрэгжилтийг хангуулан, хяналт тавьж хагас, бүтэн жилээр биелэлтийг авч үнэлэлт дүгнэлт өгч ажиллаж байна. | 100 |
| 38 | Аймгийн Засаг дарга болон Сумын Засаг даргын хооронд төрийн зарим чиг үүргийг 2024 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг бэлтгэж, баталгаажуулан гүйцэтгэлд хяналт | Сумдын тоо | 18 | 18 | I улирал | Аймгийн Засаг дарга болон Сумын Засаг даргын хооронд төрийн зарим чиг үүргийг 2024 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр байгуулж, үйл ажиллагаанд хяналт тавьж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зүнэлгээ хийлгэхэд хамтран ажиллах | | | | | гүйцэтгэлийн тайланг татан авч үнэлгээ хийж ажиллаж байна. | |
| 39 | Байгууллагын дарга нарын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, хянаж, баталгаажуулан гүйцэтгэлийг хангуулах | Байгууллагын тоо | 11 | 12 | I улиралд | Төрийн байгууллагын удирдлагуудтай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдөр баталгаажуулан хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар хянан үнэлгээ өгч ажиллаж байна. | 100 |
| 40 | Аймгийн төвийн албан байгууллагуудын дарга, эрхлэгч нарын шуурхай хурлыг долоо хоног бүр зохион байгуулж, үр нөлөөг сайжруулахад анхаарах | Зохион байгуулсан шуурхай хурлын тоо | 25 | 32 | I-IV улиралд | Төрийн байгууллагын дарга эрхлэгч нарын шуурхай хурлыг жилийн эцсийн байдлаар 38 удаа зохион байгуулж, хурлын тэмдэглэл хөтлөн, аймгийн удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн хэрэгжилтийг цаг тухай үед нь хангуулах, шуурхай хуралд ирц муутай хамрагдсан байгууллагын удирдлагуудад 61 удаагийн албан бичиг хүргүүлж ажиллалаа. Цаг үеийн шинжтэй үүрэг чиглэлийн хэрэгжилтийг хангуулах, шуурхай удирдлагаар хангахад чиглэсэн шуурхай хурлын үр дүнд ажлын гүйцэтгэл, үр нөлөө сайжирч байна. | 100 |
| 41 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.14 дэх заалтыг хэрэгжүүлж, хавсран гүйцэтгэсэний урамшууллыг олгох асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах | Арга хэмжээний тоо | - | 1 | I-IV улиралд | Онцгой байдлын салбар нэгжгүй сум, суурин газарт гамшгаас хамгаалах асуудлыг сумын Засаг даргын Тамгын газрын аль нэг албан тушаалтанд хавсран гүйцэтгүүлж, урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу төсөвтөө багтаан шийдвэрлэх тухай чиглэлийг сумын Засаг дарга нарт албан бичгээр хүргүүлсэн. | 70 |
| 42 | Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авах, түүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | Судалгааны тоо | 1 | 2 | I-IV улиралд | “Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа”-ны талаар нийт 63 иргэнээс санал асуулгыг авсан бөгөөд иргэдийн ерөнхий сэтгэл ханамжийн түвшинг 1-5 хүртэл оноогоор үнэлэхэд 4 буюу “сайн” гэсэн үнэлгээтэй байна. Төрийн байгууллагын үйл ажиллагааны түвшинг үнэлэхэд дундаж нь 4 буюу “сайн” үнэлгээтэй, Иргэдээс төрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллага албан тушаалтанд хандаж иргүүлсэн өргөдөл гомдолын шийдвэрлэлтийн талаарх сэтгэл ханамжид 4 буюу "сайн", Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг үнэлэхэд 5 буюу "онц" үнэлгээтэй, Төрийн албан хаагчийн ёс зүйн түвшинг үнэлэхэд 4 буюу "сайн" гэсэн үнэлгээтэй байна. Иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг улирлаар тогтмол хийж хангалтгүй үнэлгээ авсан үйл ажиллагааны чиглэлээр тухай бүр тодорхой арга хэмжээ авч ажиллаж байна. | |
| Зорилт 1.9. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллаж, цаг үеийн бодит мэдээ мэдээллийг бэлтгэн олон нийтэд шуурхай хүргэнэ. | | | | | | | |
| 43 | Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан, хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн, тайланг авч үнэлэлт дүгнэлт өгөх | Хамтран ажиллах гэрээний тоо | 3 | 3-аас доошгүй | I-IV улиралд | Жилийн эцсийн байдлаар хэвлэл мэдээллийн 6 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнд: Орон нутгийн "Алтай телевиз", "Алтайн мэдээ агентлаг", "Миний Алтай social tv", Улаанбаатар хотын UBS телевиз болон Ulsturch.mn, Erennews.mn сайт багтаж буй өгөөд аймаг, орон нутгийн мэдээ мэдээллийг бэлтгүүлж, олон нийтэд түгээн ажиллалаа | 100 |
| 44 | Аймаг орон нутгийн цаг үеийн мэдээ мэдээллийг тогтмол, шуурхай иргэд олон нийтэд мэдээлэх, сурталчилах | Мэдээллийн тоо | 350 | 400-аас доошгүй | I-IV улиралд | Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд болон төвийн мэдээллийн сайт, Засаг даргын Тамгын газрын пэйж хуудас зэрэг сувгуудаар Говь-Алтай аймгийн цаг үеийн мэдээ, мэдээлэл, видео контентийг түгээж ажилласан. | 100 |
| 45 | Аймгийн Засаг даргын илтгэл, мэдээлэл, цахим танилцуулга, судалгаа, шагнал үнэмлэх болон бусад шаардлагатай хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, цахим архив үүсгэх | Эх бэлтгэл, мэдээллийн тоо | 40 | 50-аас доошгүй | I-IV улиралд | Засаг даргын илтгэл, цахим танилцуулга болон үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан сэтгүүлийг эмхэтгэн гаргав. Мөн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй арга хэмжээний шаардагдах эх бэлтгэл, шагналын үнэмлэх болон бусад шаардлагатай эх бэлтгэл зэрэг 3000 гаруй хуудас хэвлэлийн эх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлтгэсэн. | |
| **Зорилт 1.10. Төсөв, санхүүгийн чиглэлээр** | | | | | | | |
| 46 | Байгууллагын төсөв, хөрөнгө санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | I-IV улиралд | Энэ онд 6570348500 төгрөгийн төсвөөс санхүүжилт авч өр авлага үүсгэхгүй ажиллалаа.<br>Батлагдсан төсөвт багтаан зардлын хуваарийг батлуулан, төсвийн зарцуулалтыг сар, улирлаар гарган хэтрэлт хэмнэлтийг тооцон удирдлагад мэдээллэж, хэтрүүлсэн зардлыг зогсоох болон бусад арга хэмжээ авч , санхүүгийн тайлангуудаа цаг хугацаанд нь гарган нэгтгүүлж, санхүүгийн зөрчил гаргалгүй ажилласан. | 100 |
| 47 | Байгууллагын өдөр тутмын бэлэн ба бэлэн бус гүйлгээг хийж, харилцах дансны хуулга боловсруулан нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг сайжруулж, зөрчилгүй ажиллана. | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | I-IV улиралд | Байгууллагын өдөр тутмын бэлэн ба бэлэн бус гүйлгээг хийж, харилцах дансны хуулга боловсруулан НББ-ийг ОУБС-д нийцүүлэн хөтлөж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан сар улирал бүр санхүүгийн тайлангаа гарган ажилласан. | 100 |
| 48 | Өмч хамгаалах байнгын зөвлөлтэй хамтран эд хөрөнгийн тооллогыг журмын дагуу гүйцэтгэх, тайлагнах | Тооллого, тайлангийн тоо | 2 | 2 | II,IV улиралд | Эд хөрөнгийн тооллогыг хагас жилээр, жилийн эцсээр 2 удаа тоолж журмын дагуу тайлагнасан. | 100 |
| **Зорилт 1.11. Архив, албан хэрэг хөтлөлт чиглэлээр** | | | | | | | |
| 49 | Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг зохих хууль журмын дагуу зохион байгуулж, шилжүүлж ажиллах | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | I-IV улиралд | 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 3447 албан бичиг хүлээн авч 2108 бичиг хугацаанд нь шийдвэрлэж, 1475 албан бичиг гадагш явуулсан байна. | 100 |
| 50 | Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, хугацаа хэтэрсэн хариутай бичгийн мэдээг 7 хоног бүр удирдлагад танилцуулан шийдвэрлүүлж ажиллах | Шийдвэрлэлтийн хувь | 100 | 90 хувиас доошгүй | I-IV улиралд | Байгууллагад ирсэн хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж хяналт тавьж, хариу өгсөн албан бичгийг хааж шийдвэрлэсэн. Байгууллагад ирсэн хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, хариу өгсөн албан бичгийг хааж шийдвэрлэн хяналт тавьж ажилласан. 2108 албан бичиг хугацаанд нь шийдвэрлэж хариутай бичгийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрлэлтийн явц 86.6% -тай байна. | |
| 51 | Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, баримт хүлээн авах хуваарийг батлуулж, хүлээн авах, бүртгэл үйлдэн ээнжүүлж ажиллах | Хуваарийн дагуу хүлээн авсан баримтын тоо | 70 жил-11хн Байнга-75хн Түр-344хн | 70 жил-12хн Байнга-79хн Түр-344хн | I,II улиралд | ТЗУХ, ХЭЗХ, ХШҮХ, СТСХ, ХБТХОХ, НБХ хэлтсийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хүлээн авлаа. 2024 оны 06 дугаар сарын 03-10-ны өдрүүдэд хэлтсүүдээс хадгаламжийн нэгжийг авах хуваарь гаргаж, хуваарийн дагуу байнга 80 ш, түр 180 ш, 70 жилийн 14 ш нийт 274 хадгаламжийн нэгжийг хэлтсүүдээс хүлээн авч ажиллаа. | 100 |
| 52 | Хадгаламжийн нэгжид тооллого хийж, цахим дэлгэрэнгүй бүртгэлтэй болгон ашиглалтыг сайжруулах | Тооллогын тоо | - | 1 | I,II улиралд | 2024 оны 06 сарын 5-ны өдрөөс эхлэн архивын баримтанд тооллого хийж байнга 625 ш, түр 1723 ш, 70 жилийн 172 ш баримтанд тооллого хийлээ. -<br>Хуучин архивын өрөөний тавиурын багтаамж багадсаны улмаас 2024 оны 07 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд шинээр архивын өрөөг тохижуулан, 6 сектортэй тавиур ашиглалтад оруулж, ажилд ашиглахад бэлэн болгон хүлээлгэн өгсөн. Архивын<br>2024 оны 10 дугаар сарын 25-наас эхлэн архивын хуучин өрөөнөөс биллярьдны өрөө архивын баримтнуудын сэлгэн зөөж 70 жил - 172 ш, түр- 1723 ш баримтыг зөөж ажиллалаа. | 100 |
| **ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | | |
| Зорилт 2.1. Төрийн албан хаагчдын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр | | | | | | | |
| 53 | Ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас авах, ажиллах нөхцлийг сайжруулах ажил зохион байгуулах | Судалгаанд хамрагдалтын хувь, арга хэмжээний тоо | - | 1 судалгаа | II улиралд | "Чанарын менежментийн тогтолцоо, шаардлага" ISO 9001:2015 олон улсын стандартыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлын хүрээнд ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас авч, нэгтгэн, Тамгын газрын даргад танилцуулсан. | 100 |
| 54 | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг, нийтийн болон | Мэдүүлэг, Мэдэгдэл, | 2 | 3-аас доошгүй | I-IV улиралд | Хэлтсийн дарга Я.Жаргалцэцэг, Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг цаг тухай бүрт тайлагнах | тайлбарын тоо | | | | дарга М.Туул, ахлах мэргэжилтэн Р.Мягмаржаргал нар хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд мэдүүлсэн. Хэлтсийн дарга Я.Жаргалцэцэг нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг 10 удаа тайлагнав. | |
| 55 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримтуудыг цаасан, цахим байдлаар хүлээлгэн өгөх | Хүлээлгэн өгсөн хадгаламжийн нэгжийн тоо | 70 жил - 5хн Байнга - 20хн Түр – 38хн | 70 жил - 6хн Байнга - 21хн Түр – 40хн | I-II улиралд | Хэлтсийн ажилтан, албан хаагчдаас хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу нийт 187 архивын баримтуудыг цаасан байдлаар хүлээн авсан. Үүнээс байнга – 32, 70 жил- 11, түр-144 баримтыг хүлээж авсан. | 100 |
| 56 | Сар бүрийн тайланг заасан хугацаанд холбогдох хэлтэст гаргаж хүргүүлэх | Тайлангийн тоо | 12 | 12 | I-IV улиралд | Сар бүр хийсэн зохион байгуулсан ажлын тайлан мэдээг хугацаанд нь тайлагнаж ажилласан.<br>7 хоног бүр ажлаа төлөвлөж, тухайн төлөвлөсөн ажлаа хийсэн эсэхийг бүртгэж байх зорилгоор хэлтсийн албан хаагч бүрт дэвтэр гарган ашиглах аргыг шинээр нэвтрүүлсэн. | 100 |
| 57 | Хэлтсийн сарын ажил, арга хэмжээг албан хаагчдыг хамруулан үр дүнтэй зохион байгуулах, бусад хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаанд идэвхи, санаачлагатай оролцох | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 5 | 5-аас доошгүй | III,IV улиралд | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 2024 оны 10,11 дүгээр сард хэлтсийн сарын ажлыг зохион байгуулж, сургалт, мэдээлэл, спортын болон буухиа тэмцээн, чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтийг сайжруулах зэрэг 23 ажлыг зохион байгуулж ажиллалаа.<br>Мөн бусад хэлтсүүдээс зохион байгуулж буй бүх арга хэмжээнд үр дүнтэй, зохион байгуулалттайгаар тасралтгүй идэвхтэй оролцсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2. Систем хөгжүүлж, мэдээллийн сан бүрдүүлж иргэдийг мэдээллээр хангах | | | | | | | |
| 58 | Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь оруулах, ил тод байдлыг хангах, хуулийн хугацаанд тайлагнах | Мэдээллийн тоо | 159 | 159 | I-IV улиралд | Төсвийн удирдлагыг хэрэгжүүлэн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж байна. www.shilendans.gov.mn цахим хаягт 26 мэдээллийг хугацаанд нь байршуулж төсвийн ил тод байдлыг хангаж ажиллаж байна. | 100 |
| ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ | | | | | | | |
| Зорилт 3.1 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг уялдуулан төлөвлөрүүлж, иргэн аж ахуй нэгж байгууллагад төрийн үйлчилгээг нэг цэгээс ил тод, түргэн шуурхай хүргэн ажиллаж төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөжүүлнэ. | | | | | | | |
| 59 | Төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлэн, үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор “Цахим Алтай” арга хэмжээ хэрэгжүүлж, үйлчилгээний нэгдсэн төвөөр үзүүлэх үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлнэ. | Үйлчилгээ үзүүлж буй байгууллага, үйлчилгээний тоо | 7 байгууллага, 158 төрлийн үйлчилгээ | 6 байгууллага, 140 төрлийн үйлчилгээ | I-IV улиралд | Төрийн үйлчилгээ арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, засаглалын бодлого, шийдвэрийн хэрэгжилт, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, шуурхай, хүртээмжтэй болгох, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэсэн, ил тод, цахим үйлчилгээг хүргэхээр Үйлчилгээний нэгдсэн төвөөр 5 байгууллагын 899 нэр төрлийн үйлчилгээг цахимаар болон биечлэн үзүүлж, давхардсан тоогоор нийт 20,029 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. | 100 |
| 60 | Erp.emongolia.mn системийн нэвтрэлт, ашиглалтыг бүрэн хэрэгжүүлж, цагийн бүртгэлээр цалингийн тооцоо хийж хэвшүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах | Цагийн бүртгэлээр цалин тооцсон сарын тоо | - | 10 | I-IV улиралд | Erp.emongolia.mn системээр албан хаагчдын албан бичиг солилцох, бусад төрийн байгууллагруу бичиг илгээх боломжийг хангаж албан хаагчдын цаг бүртгэлийг цахимжуулан 2024 оны 2-р сараас эхлэн цагийн бүртгэлээр цалинг тооцон олгож байна. | 100 |
| 61 | Төрөөс цахимжуулж буй үйлчилгээг иргэд олон нийтэд сурталчлан таниулж, хэрэглээнд сургаж дадлагажуулан, төрийн шат дамжлага, хүнд суртлыг арилгахад анхаарч ажиллана. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 2 | I-IV улиралд | Төрөөс цахимжуулж буй үйлчилгээг иргэд олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас болон төв талбайн дэлгэцийг ашиглан сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 62 | Аймгийн Засаг даргын хэвлэл мэдээллийн ажлыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх, хадгалах, архивлах ажлыг зохих түвшинд хариуцан гүйцэтгэх | Мэдээллийн багтаамж | 2-3ТВ Терабайт | 3ТВ Терабайт | I-IV улирал д | Аймгийн Засаг даргын хэвлэл мэдээллийн ажлыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх, хадгалах, архивлах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2020-2024 оны ажлын тайлангийн материал зэрэг баримтуудыг Хяналт шинжилгээний үнэлгээний хэлтэст 3 Терабайт хард дээр хадгалан хүлээлгэж өгсөн. | 100 |
| **Хэрэгжилтийн дундаж хувь** | | | | | | **97.5 хувь** | |

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

ДАРГА Я.ЖАРГАЛЦЭЦЭГ

НЭГТГЭСЭН:

ГАДААД ХАРИЛЦААНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН Б.МӨНХЖАРГАЛ

## МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

| № | Ажил, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хариуцсан чиг үүргийн хүрээнд зохион байгуулагдах сургалт, уулзалт, хэлэлцүүлэгт хамрагдах | Хамрагдсан сургалт, уулзалтын тоо | 5-аас доошгүй | Төрийн албаны зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Удирдлагын академиас зохион байгуулсан Ёс зүйн тухай хуулийн сургалт, Сонгуулийн тухай хуулийн сургалт, Төрийн албан хаагчийн хөгжил, хамгаалал , Орон нутгийн сонгууль зохион байгуулах ажилтнуудыг чадавхижуулах сургалт зэрэг 6 сургалтад хамрагдсан.<br><br>Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Нутгийн удирдлагын хөгжлийн институттэй хамтран хэрэгжүүлж байгаа Монгол Улсын нутгийн захиргааны байгуулллагын удирдах албан тушаалтнуудыг чадавхжуулах хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалтад 2024 оны 04 дүгээр сарын 21-ээс 27-ны өдрүүдэд БНСУ-д хамрагдсан.<br><br>Сургалтын хугацаанд дараах сэдвүүдээр үндсэн лекц, хичээлүүдийг холбогдох яам, төрийн байгууллагуудын удирдах түвшний албан хаагчид орсон. Үүнд:<br>o Нутгийн захиргааны бодлого<br>o Нутгийн захиргааны боловсон хүчний тогтолцоо, гүйцэтгэлийн удирдлага<br>o Үндэсний брэндийн стратеги, жишээ<br>o Дижитал платформ төр, төрийн үйлчилгээг сайжруулах<br>Мөн Жеонжу аймгийн Ванжу сумын захиргаа, Ванжу сумын захиргааны дэргэдэх NU-E урлагийн галарей, Нутгийн брэнд бүтээгдэхүүний цогцолбор, Сэжонг хотын камерын удирдлагын төв, Мэдээллийн технологийн үндэсний төв, Сөүл хотын Чёнгэчон голын бүтээн байгуулалтын ажлуудтай танилцаж, дадлага хичээлүүд орсон. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Үндэсний бичгийн сургалтад бүрэн хамрагдах, мэдлэгээ сайжруулах | Мэдлэгийн түвшин | Түвшинг ээ ахиулсан байна. | Байгууллагын албан хаагчдаас авсан түвшин тогтоох шалгалтаар 82 оноо авсан. Мэдлэгийн түвшингээ ахиулах зорилгоор цахим хичээлд 2 удаа хамрагдаж, бие даан суралцсан. Бие даан суралцах зорилгоор ном гарын авлага худалдан авч ашигласан. | 100 |
| 3 | Удирдлагын манлайллын чиглэлээр сургалтад хамрагдах | Сургалтын тоо | 1 | Удирдлагын академаас зохион байгуулсан “Төрийн захиргааны удирдах албан тушаалтны манлайлал” цахим сургалтад хамрагдаж 32 цагийн хичээлийг бүрэн судалж сертификат авсан. | 100 |

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА Ш.ЭРДЭНЭБАТ

ТАЙЛАГНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

ДАРГА Я.ЖАРГАЛЦЭЦЭГ

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН Б.МӨНХЖАРГАЛ